



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 09 дүгээр сарын 18
№35 (1430)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------------------|------|
| 345. | Д.Одончимэгийн нэхэмжлэлтэй, Баянзүрх
дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст холбогдох
захиргааны хэргийн тухай | Дугаар 001/ХТ2026/0016 | 2791 |
| 346. | “Мальфлюорит” ХХК-ийн нэхэмжлэлтэй,
нийслэлийн Татварын газрын татварын
улсын байцаагч нарт холбогдох захиргааны
хэргийн тухай | Дугаар 001/ХТ2026/0025 | 2802 |
| 347. | Т.Батцэцэгийн нэхэмжлэлтэй, Монополын
эсрэг газрын даргад холбогдох захиргааны
хэргийн тухай | Дугаар 001/ХТ2026/0030 | 2815 |

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 02 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар: 001/ХТ2026/0016

Улаанбаатар
хот

**Д.Одончимэгийн нэхэмжлэлтэй,
Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст
холбогдох захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:

Шүүгчид:

Д.Батбаатар

Г.Банзрагч

М.Батсуурь

П.Соёл-Эрдэнэ

Илтгэгч шүүгч:

Ц.Цогт

Нарийн бичгийн дарга:

Б.Энхжаргал

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны
08 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2025/0580 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны
11 дүгээр сарын 05-ны өдрийн 221/МА2025/0701 дүгээр магадлалтай,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2025 оны
12 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар, 2026 оны 01 дүгээр сарын
09-ний өдрийн 25 дугаар хэлэлцүүлэх тогтоолтой захиргааны хэргийг
нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Намсрай, хариуцагчийн
итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Өнөрмөнх, гуравдагч этгээд “Гурван марал
констракшн” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Энхзаяа, өмгөөлөгч
Д.Болормаа, гуравдагч этгээд “Чингис хаан банк” ХХК-ийн итгэмжлэгдсэн
төлөөлөгч Э.Золбоо, М.Цоггэрэл, гуравдагч этгээд Д.Гүрсоронз нарыг
оролцуулан, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, гуравдагч этгээд
“Гурван марал констракшн” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын
хяналтын журмаар гаргасан гомдлыг үндэслэн хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэлийн шаардлага:

1.Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, 15 дугаар хороолол,
Дамдинбазарын гудамж, 101А байрны 30 тоот хаягт байрлах 53.76 м.кв
талбай бүхий орон сууцны зориулалттай байрны өмчлөх эрхийг



Д.Одончимэгт шилжүүлэн улсын бүртгэлд бүртгэж, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гаргаж өгөхийг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст даалгах.

Хэргийн нөхцөл байдал:

2.Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, 15 дугаар хороолол, 101А тоот хаягт байршилтай 5850 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр “Гурван марал констракшн” ХХК-ийг бүртгэж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ олгосон.

2.1.Иргэн Д.Одончимэг “Гурван марал констракшн” ХХК-тай 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр 101А байранд 53.76 м.кв талбай бүхий 2 өрөө орон сууцны захиалгын гэрээ байгуулж, тус орон сууцыг худалдан авч, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхээр хандахад татгалзсан байна.

2.2.Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс “... тухайн үл хөдлөх эд хөрөнгийн газар нь ... гэр бүлийн зориулалттай бөгөөд өнөөдрийн байдлаар “Чингис хаан банк” ХХК-тай байгуулсан барьцааны гэрээнд бүртгэлтэй байна. ... газрын захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн. Түүнчлэн “Гурван марал констракшн” ХХК-ийн бүртгэлтэй барилгын захиалагчдын жагсаалтыг тус хэлтэст ирүүлээгүй” гэсэн хариуг нэхэмжлэгчид өгчээ.

3.Нэхэмжлэгчээс “Иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр миний өмчлөлийг баталгаажуулсан, шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явагдаж, орон сууцны өмчлөх эрхийг Д.Одончимэгийн нэр дээр шилжүүлэх албан бичгийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлсэн, нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газраас тус байр байрлаж буй газар, үл хөдлөх хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан шийдвэр хүчингүй болсон гэсэн хариуг ирүүлсэн байтал бүртгэлийн байгууллага нь хуучин хүчингүй болсон шийдвэрүүдийг үндэслэл болгон бүртгэхээс татгалзаж байгаа нь үндэслэлгүй, миний хувьд газрын эрхийг хүсээгүй, зөвхөн шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өмчлөх эрхээ бүртгүүлэхээр хандсан, ... миний үл хөдлөх эд хөрөнгөө бүртгүүлэх эрхийг удаа дараа хойшлуулж, бүртгэхээс татгалзсан шийдвэрийн улмаас олон жил хохирч байна” гэж маргажээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр:

4.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2025/0580 дугаар шийдвэрээр: Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4.3, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр

зүйлийн 4.4, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.1.3-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Д.Одончимэгээс Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст холбогдуулан гаргасан “Баянзүрх дүүрэг, 22 дугаар хороо, 15 дугаар хороолол, 101А дугаар байрны 30 тоот хаягт байрлах 53.76 м.кв талбай бүхий орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийг Д.Одончимэгийн нэр дээр бүртгэхээс татгалзсан шийдвэр хууль бус болохыг тогтоолгож, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ гаргахыг даалгах” шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

5.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 221/МА2025/0701 дүгээр магадлалаар: нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2025/0580 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, гуравдагч этгээд “Гурван марал констракшн” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисон байна.

Хяналтын журмаар гаргасан гомдол:

6.Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Намсрай шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргажээ. (Гомдлыг агуулгаар тусгав)

6.1.Уг орон сууцны доорх газар нь иргэн Д.Гүрсоронзын өмч бөгөөд уг орон сууцны зориулалттай барилгыг Д.Гүрсоронзын захиалгаар “Гурван марал констракшн” ХХК барьж, хуулийн дагуу комиссын дүгнэлтээр ашиглалтад оруулж газар өмчлөгчийн зөвшөөрлөөр 100 хувь “Гурван марал констракшн” ХХК-ийн өмчлөлд шилжүүлсэн байдаг. Орон сууцны зориулалттай байрныхаа тодорхой хэсгийг хуулийн дагуу бусдад шилжүүлэх эрхийнхээ хүрээнд Д.Одончимэгт гэрээний үндсэн дээр борлуулсан.

6.2.Иргэний хэргийн шүүхэд хандан өмчлөгчөө тогтоолгож, улмаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийлгэж байгаа болно. Энэ хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас Улсын бүртгэлийн байгууллагад “... 30 тоотод байрлах үл хөдлөх хөрөнгийг Д.Одончимэгт ... өмчлөлд бүртгэж, бусад орон сууцны хоригийг хэвээр үлдээж, гэрчилгээний хуулбарын хамт ирүүлэхийг мэдэгдье” гэсэн 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/189/9039 тоот албан бичиг хүргүүлсэн байдаг. Энэ хүрээнд миний бие Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т заасны дагуу өргөдөл гарсан.



6.3. “Гурван марал констракшн” ХХК нь шүүхийн шийдвэрийн дагуу материалаа бүрдүүлэн улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлсэн байдаг бөгөөд бусад газарт мэдэгдэх үүргээ улсын бүртгэл гүйцэтгээгүй тул эдгээр эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдүүд “зөвшөөрөх эсэх” мэдэгдлийг авах боломжгүй болж дараа шатанд иргэний хэргийн эсвэл эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэгдэх боломжийг хаасан.

6.4. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр өмчлөгчөө тогтоолгон Улсын бүртгэлийн байгууллагад хуулийн дагуу өргөдөл гаргасан тул хуулийн 11.3-т заасны дагуу улсын бүртгэлийн байгууллага зөвшөөрлийг /зөвшөөрөх, эс зөвшөөрөх аль нь байхыг/ авах үүрэгтэй байна. Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэгчийг барьцаалагчаас зөвшөөрөл авах ёстой гэж үзэн хуулийг буруугаар тайлбарлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон нь хууль бус гэж үзэж байна.

6.5. Нэхэмжлэлд дурдсан байр байрлаж буй орон сууцны зориулалттай барилга нь барьцаанд байхгүй гэдэг нь баримтаар нотлогдож байгаа бөгөөд үүнийг 100 хувь өмчилж байгаа этгээд болох “Гурван марал констракшн” ХХК нь өөрийн өмчийн хэсгийг бусдад зарж борлуулах бүрэн эрхтэй бөгөөд шаардлагатай бол доорх газрыг барьцаалагчаас зөвшөөрөл авах үүрэг нь барьцаалуулагчид байх байтал надад ногдуулж байгаа нь хууль бус юм.

6.6. Нэхэмжлэгч “Чингис хаан банк” ХХК-аас зээл аваагүй, зээл төлж газрыг барьцаанаас чөлөөлүүлэх үүрэггүй, мөн газрын зориулалтыг өөрчлөх боломжгүй бөгөөд хуулиар тогтоосон эрхгүй байхад газрын зориулалтыг өөрчлөх шаардлагатай гэсэн шалтгаанаар миний нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон нь хуульд нийцэхгүй байна. Харин эрх, үүрэг хүлээсэн этгээдэд даалгаж, тэр нь хангагдах хүртэл өөр бусад этгээдэд шилжүүлэх боломжгүй болгох шаардлагаар улсын бүртгэлийн байгууллагад хувийн хэрэгт тэмдэглэл хийлгэх үүргийг даалгаж шийдвэрлэх нь хууль хэрэглээний зарчимд нийцэх юм.

6.7. Тухайн газрын эзэн нь зөвшөөрөөд байхад шүүхийн шийдвэрээр өмчлөх эрхээ тогтоолгосон байрыг бүртгэхгүй, ядаж бүртгэл хийхэд шаардлагатай хуульд тодорхой зааж өгсөн “... эрх ашиг нь хөндөгдөж болох этгээдэд улсын бүртгэлийн байгууллага энэ тухай бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ” гэсэн үүрэгт ажлаа хийхгүй байхад шүүхээс үүнийг зөв мэтээр тайлбарлаж нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож байгаад гомдолтой байна.

6.8. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүд нь хуулийн дагуу ажлаа хийхгүй байгаа улсын бүртгэлийн байгууллагыг

өөгшүүлж, хуулийг ялгавартайгаар, дураар тайлбарлан хэрэгжүүлэхийг илтэд дэмжсэн байх тул миний гаргасан тайлбар, дурдсан нотлох баримтуудыг харгалзан үзэж иргэний хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр тогтоосон өмчлөх эрхийг бүртгэхтэй холбоотой хуульд заасан ажлуудаа бүрэн хийж улсын бүртгэлд бүртгэх, ядаж урьдчилсан тэмдэглэл хийх зэрэг хуульд заасан улсын бүртгэлийн үйл ажиллагаагаа хийхийг улсын бүртгэлийн байгууллагад даалгаж нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэж өгнө үү гэжээ.

7.Гуравдагч этгээд “Гурван марал констракшн” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ч.Энхзаяа шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргажээ. (Гомдлыг агуулгаар тусгав)

7.1.Шийдвэр, магадлалыг бүхэлд нь эс зөвшөөрч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.2-т заасны дагуу энэхүү хяналтын гомдлыг гаргаж байна.

7.2.Шүүхийн шийдвэр үндэслэл бүхий байх зарчимд нийцэхгүй байна. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх” гэж бүртгэлийн зарчмыг заасан ч ерөнхий газар, дүүргийн хэлтэс нь өөр өөр зүйл тайлбарлаж, өмнө нь бүртгэсэн бүртгэлээ үгүйсгэж, манай компаниас орон сууц худалдан авсан олон арван шударга эзэмшигч, өмчлөгч нарын эрхийг хязгаарлаж хохироож байгаад гомдолтой байна.

7.3.Хариуцагч Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан үндэслэлээр татгалзсан байдаг. Нэхэмжлэгч болон “Гурван марал констракшн” ХХК нар нь Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасан болон Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 397 дугаар тогтоолоор батлагдсан “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 5.7-д заасан “Захиалгаар барьж дууссан барилгын дундаа хэсгээр өмчлөгч бүрд ногдох хэсгийн өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд мэдүүлэг гаргагчийн ирүүлсэн нотлох баримтыг захиалагчийн нэрс, тэдгээрийн оруулсан хөрөнгийн болон ногдох талбайн хэмжээ, байршлын хаяг, хэлцлийн мэдээллийг тусгасан захиалагчдын нэрсийн жагсаалт” зэрэг бүрдүүлбэл зохих нотлох баримтуудыг бүрэн хавсаргасан байхад захиргааны байгууллага нь дээрх үндэслэлээр татгалзсан нь хуульд нийцэхгүй.

7.4.Тус байрны тодорхой нэг хэсэг буюу 53.76 м.кв талбайг хэлцлийн үндсэн дээр Д.Одончимэгт шилжсэнийг бүртгэх боломжгүй гэх захиргааны байгууллагын татгалзал үндэслэлгүй байхад түүнийг хуульд



нийцсэн гэж үзсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр бодит нөхцөл байдлыг үнэн зөвөөр тогтоогоогүй.

7.5.Өөрөөр хэлбэл, маргаан бүхий үл хөдлөх хөрөнгө газрын нэгж талбарт суурилан 2019 он, 2020 онд бүртгэгдсэн тул нэхэмжлэгчийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дагуу орон сууцны өмчлөгч өөрчлөгдсөнтэй холбоотойгоор бүртгэл хийлгэх хүсэлт хуульд нийцсэн байсан.

7.6.Хариуцагчаас анхан шатны шүүхэд нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагын хүлээн зөвшөөрөхгүй байгаа татгалзлаа бичгээр тайлбар гаргахдаа зөвхөн манай компанийн захиалагч иргэдийн нэр дээрх гаргах жагсаалт болон холбогдох нотлох баримтыг ирүүлээгүй гэж буруутган тайлбар хийсэн. Гэтэл бодит байдалд “Гурван марал констракшн” ХХК-ийн зүгээс Баянзүрх дүүргийн Эд хөрөнгийн эрхийн Улсын бүртгэлийн газарт өөрийн барьж ашиглалтад оруулсан орон сууцны төлбөрийг 100 хувь төлсөн захиалагчийн нэр дээр гэрчилгээг гаргуулахаар 2020 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 322 тоот албан бичгээр, 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 235 тоот албан бичгээр, 2023 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 52 тоот албан бичгээр, 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн албан бичгээр тус тус хандсан байдаг. Түүнчлэн манай компани нь дээрх албан бичгээр захиалагч иргэдийн жагсаалт болон холбогдох нотлох баримтыг хавсаргаж өгсөн үйл баримт хавтаст хэрэгт авагдсан бөгөөд захиргааны байгууллагын татгалзал үндэслэлгүй болно.

7.7.Хэдийгээр маргаан бүхий барилга байршиж буй газар нь гуравдагч этгээд “Чингис хаан банк” ХХК-ийн барьцааны гэрээгээр бүртгэлтэй, эрх бүхий байгууллагуудаас барилгыг удаа дараа битүүмжилж байсан боловч хамгийн сүүлд хөрөнгийн эрх сэргээх тухай 189/07 дугаар тогтоол, эрх шилжүүлэх тухай 01-189/9039 дугаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын эрх бүхий албан тушаалтны албан бичгээр маргаан бүхий үл хөдлөх хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээж шийдвэрлэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, тус маргаан бүхий орон сууц болон түүний доорх газрын эрхийг хязгаарласан шүүхийн маргаангүй, хязгаарлалтгүй, бусад хууль хяналтын байгууллагуудаас тавигдсан хөрөнгийн шилжилт хөдөлгөөний хязгаарлалт байхгүй болох нь дээрх албан бичгээс нотлогдож байна. Иймд шийдвэр, магадлалыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

8.Гуравдагч этгээд “Чингис хаан банк” ХХК-аас хяналтын журмаар гаргасан гомдлуудтай холбогдуулж эс зөвшөөрсөн тайлбар бичгээр ирүүлсэн байна.

9.Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нэхэмжлэгчийн

итгэмжлэгдсэн төлөөлөгч, 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 25 дугаар тогтоолоор гуравдагч этгээд “Гурван марал констракшн” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2, 123.2.3-т заасан үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

ХЯНАВАЛ:

10.Дараах үндэслэлээр шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэлээ.

Тогтоогдсон үйл баримтын тухайд:

11.Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, 15 дугаар хороолол, 101А тоот хаягт байршилтай 5850 м.кв талбай бүхий, орон сууцны зориулалттай 90 хувийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр “Гурван марал констракшн” ХХК-ийг 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдөр бүртгэж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ олгосон. Хожим 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр 100 хувийн гүйцэтгэлтэй үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр бүртгэгдэж, гэрчилгээ авсан байна.

12.Нэхэмжлэгч Д.Одончимэг нь Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, 15 дугаар хороолол, 101А байрны 5 давхрын 30 тоот, 53.76 м.кв талбай бүхий 2 өрөө орон сууцыг худалдан авахаар “Гурван марал констракшн” ХХК-тай 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр “Орон сууц захиалгын гэрээ” байгуулж, гэрээний дагуу төлбөрийг 2019, 2020 онд бүрэн төлж барагдуулжээ.

13.Нэхэмжлэгчийн худалдаж авсан орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн доорх газар нь иргэн Д.Гүрсоронзын өмчлөлд бүртгэлтэй. Тухайн газар нь “Гурван марал констракшн” ХХК, “Чингис хаан банк” ХХК-ийн хооронд байгуулагдсан 2018 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний дагуу барьцаалагдсан байна.

14.Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 102/ШШ2022/1087 дугаар захирамжаар Д.Одончимэгийн “... үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчөөр тогтоолгох, орон сууц үл хөдлөх хөрөнгийн бүртгэлтэй холбоотой баримт бичгийг шилжүүлж өгөхийг хариуцагчид даалгах тухай” нэхэмжлэлийн шаардлагыг “Гурван марал констракшн” ХХК бүрэн хэмжээгээр хүлээн зөвшөөрсөн тул хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.



15.Дээрх Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гарсны дараа Д.Одончимэгээс тухайн үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээг өөрийн нэр дээр шилжүүлэн бүртгүүлэхээр бүртгэлийн байгууллагад хэд хэдэн удаа хандсан, хариуцагч Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс "... 101А тоот хаягт байршилтай үл хөдлөх хөрөнгө нь "Гурван марал констракшн" ХХК-ийн өмчлөлд бүртгэлтэй, тухайн үл хөдлөх эд хөрөнгийн газар нь эрхийн улсын бүртгэлийн Г-2204014857 дугаарт бүртгэлтэй, гэр бүлийн зориулалтай, өнөөдрийн байдлаар "Чингис хаан банк" ХХК-тай 2018 онд байгуулсан №ББГ-2018/ЗГ/69 дугаартай барьцааны гэрээ бүртгэлтэй, прокурорын зөвшөөрөл болон нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан бичгээр дээрх газар болон үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн, улсын бүртгэгчийн улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан шийдвэр үндэслэлтэй ..." гэж 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр албан бичгээр хариу хүргүүлсэн байна.

Энэхүү хэргийн хувьд хяналтын шатны шүүхээс хариу өгөх шаардлагатай хууль зүйн асуудал нь:

-Газар нь барьцаанаас чөлөөлөгдөөгүй тохиолдолд дээр нь баригдсан нийтийн зориулалттай орон сууцны өмчлөх эрхийг улсын бүртгэлд салгаж бүртгэхэд газар барьцаалагчийн зөвшөөрлийг авах эсэх,

-Хариуцагчийн орон сууцны өмчлөх эрхийг салгаж бүртгэхээс татгалзсан үндэслэл нь хуульд нийцсэн эсэх тухай байна.

Хууль хэрэглээний хувьд:

16.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т "Орон сууц болон хэсгээр өмчлөх дундын өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг тухайн үл хөдлөх эд хөрөнгийн доорх болон орчны газрын нэгж талбарын дугаарт үндэслэн бүртгэнэ", 11 дүгээр зүйлд "Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг бүртгэх", 11.1.1-д "мэдүүлэг гаргасан он, сар, өдөр", 11.1.2-т "эрх шилжүүлэн авч байгаа этгээд нь иргэн бол иргэний овог, эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, хуулийн этгээд бол түүний оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, регистрийн дугаар", 11.1.3-т "гэрээ, хэлцлийн нэр, төрөл", 11.1.4-т "эрх бүхий этгээдийн шийдвэрээр эрх шилжиж байгаа бол шийдвэрийн нэр, он, сар, өдөр, дугаар", 11.1.5-д "хөрөнгийн үнэ", 11.2-т "Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрх гэрээ, хэлцлийн үндсэн дээр шилжиж байгаа бол гэрээ, хэлцлийн эх хувийг хувийн хэрэгт хавсаргана" гэж тус тус заажээ.

17.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журмын Зургаадугаар зүйлд үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй

холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг бүртгэх харилцааг зохицуулсан. Журмын 6.1-д “Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн шилжилтийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмыг баримтална” гээд 6.2-т гэрээ, хэлцлийн үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх өөр этгээдэд шилжсэнийг эрхийн улсын бүртгэлд бүртгэхэд тавигдах 7 шаардлагыг жагсаасны дотор нийтийн зориулалтаар баригдсан орон сууцны доорх газартай холбоотой баримтыг өргөдөл гаргагч бүрдүүлж өгөх талаар тусгагдаагүй, тодруулбал, орон сууц баригдсан газрын барьцаалагчаас зөвшөөрөл авах шаардлага тавигдаагүй байна.

18.Гуравдагч этгээд “Гурван марал констракшн” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 5850 м.кв талбайтай, орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгөөс хэлцлийн үндсэн дээр үл хөдлөх эд хөрөнгийн эрхийн тодорхой хэсгийг нэхэмжлэгчид салгаж бүртгэхэд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4-т зааснаар тухайн үл хөдлөх эд хөрөнгийн доорх болон орчны газрын нэгж талбарын дугаарт үндэслэн бүртгэх үүрэгтэй, тухайн газартай холбоотой бусад баримтуудыг шаардаж, түүнд үндэслэн бүртгэл хийхээс татгалзах зохицуулалт байхгүй байна.

19.Өөрөөр хэлбэл, хариуцагч улсын бүртгэлээс тухайн үл хөдлөх эд хөрөнгийн доорх газар гэр бүлийн хэрэгцээний зориулалттай, барьцаалагчийн зөвшөөрөл шаардлагатай гэж хууль, журамд заагаагүй шаардлага тавьж үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг салгаж бүртгэхээс татгалзсан нь үндэслэлгүй.

20.Түүнчлэн Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 2022/ШТ/160 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, Өлгий 18-р гудамж, 245 тоотод байрших Г-2204014857 гэрчилгээний дугаартай 700 м.кв газрыг битүүмжилсэн, хөрөнгийн шилжилт хөдөлгөөн хязгаарласан шийдвэрүүдийг хүчингүй болгосон, мөн Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01-189/9039 дүгээр албан бичгээр нэхэмжлэгчийн үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг сэргээсэн талаар хариуцагчид хүргүүлсэн байхад хариуцагчаас “газар болон үл хөдлөх эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн” гэж татгалзсан нь үндэслэлгүй.

21.Анхан болон давж заалдах шатны шүүхээс “маргаан бүхий үл хөдлөх эд хөрөнгийн доорх газар нь иргэнд өмчлүүлэх газар болох нь тогтоогдсон, тухайн газрын зориулалтыг өөрчлөх шаардлагатай, нэхэмжлэгчийг тус орон сууцны өмчлөгчөөр бүртгэхээс татгалзсан



хариуцагчийн шийдвэр хуульд нийцсэн” гэж холбогдох хууль, журмыг буруу тайлбарлан хэрэглэсэн байх тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэв.

22.Тодруулбал, олгогдсон зориулалтын хувьд гэр бүлийн хэрэгцээнд зориулж өмчлүүлсэн газар боловч бодит байдалд өмчлөгчийн зөвшөөрлөөр тухайн газар дээр нийтийн зориулалттай орон сууц баригдсан. Цаашид гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлөх боломжгүй, газар өмчлөгчөөс нэхэмжлэгчид үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ гаргаж өгөхөд татгалзах зүйлгүй болохоо илэрхийлсэн энэ тохиолдолд газрын зориулалтыг өөрчлүүлэх шаардлагатай гэж улсын бүртгэл хийхээс татгалзсан нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөнджээ.

23.Хариуцагчаас улсын бүртгэл хийхээс татгалзаж буй үндэслэлээ дээр дурдсанаар “... тухайн үл хөдлөх эд хөрөнгийн газар нь ... гэр бүлийн хэрэгцээний зориулалтай, “Чингис хаан банк” ХХК-тай 2018 онд байгуулсан барьцааны гэрээ бүртгэлтэй” гэсэн агуулгаар тайлбарлан маргасан тул шүүхээс маргааны хүрээнд дүгнэлт хийж хэргийг шийдвэрлэсэн бөгөөд барьцааны гэрээтэй холбоотой аливаа дүгнэлт өгөөгүй болохыг дурдах нь зүйтэй.

24.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.7-д шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг захиран тушаах хэлбэртэй байхаар заасныг анхан шатны шүүх анхаарвал зохино.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.4-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 128/ШШ2025/0580 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 221/МА2025/0701 дүгээр магадлалыг тус тус хүчингүй болгож, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2-т заасныг баримтлан нэхэмжлэгч Д.Одончимэгийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, Баянзүрх дүүргийн 22 дугаар хороо, 15 дугаар хороолол, Дамдинбазарын гудамж, 101А байрны 30 тоот хаягт байрлах 53.76 м.кв талбай бүхий орон сууцны зориулалттай байрны өмчлөх эрхийг Д.Одончимэгт шилжүүлэн улсын бүртгэлд бүртгэж, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ олгохыг Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст даалгаж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, гуравдагч этгээд “Гурван марал констракшн” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангасугай.



2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-д заасныг баримтлан нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нараас хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг тус тус Төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Д.БАТБААТАР

ШҮҮГЧИД

**Г.БАНЗРАГЧ
М.БАТСУУРЬ
П.СОЁЛ-ЭРДЭНЭ
Ц.ЦОГТ**

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 03 дугаар
сарын 02-ны өдөр

Дугаар: 001/ХТ2026/0025

Улаанбаатар
хот

**“Мальфлюорит” ХХК-ийн нэхэмжлэлтэй,
нийслэлийн Татварын газрын татварын
улсын байцаагч нарт холбогдох
захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:	Ц.Цогт
Танхимын тэргүүн:	Д.Мөнхтуяа
Шүүгчид:	Д.Батбаатар П.Соёл-Эрдэнэ
Илтгэгч шүүгч:	Г.Банзрагч
Нарийн бичгийн дарга:	Б.Зэнээмэдрээ

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны
10 дугаар сарын 22-ны өдрийн 128/ШШ2025/0738 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны
12 дугаар сарын 26-ны өдрийн 221/МА2026/0010 дугаар магадлалтай,

Шүүх хуралдаанд оролцогчид: Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн
төлөөлөгч Ц.Энхжавхлан, Р.Бадрах, өмгөөлөгч Б.Мөнхболд, хариуцагч
С.Эрдэнэцэцэг, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч В.Баяраа,
Д.Эрдэмбилэг нарыг оролцуулж,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн
хуралдааны 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 001/ШХТ2026/0049
дүгээр хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг Захиргааны хэрэг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.1, 123.2.3-т заасан
үндэслэл байгаа эсэхийг хариуцагчийн хяналтын журмаар гаргасан
гомдлоор хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага:

“Мальфлюорит” ХХК нь нийслэлийн Татварын газрын татварын
улсын байцаагч С.Эрдэнэцэцэг, Д.Нармандах нарт холбогдуулан “2024 оны

2 дугаар сарын 09-ний өдрийн НА-22240000013 дугаар нөхөн ногдуулалтын актыг хүчингүй болгуулах”нэхэмжлэлийн шаардлага гаргажээ.

2.Хэргийн нөхцөл байдал:

2.1.Хариуцагч татварын улсын байцаагч нар нь “Мальфлюорит” ХХК-ийн 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд татварын хяналт шалгалт хийх ерөнхий удирдамж, томилолтоор шалгалт хийж, 2024 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн НА-22240000013 дугаар нөхөн ногдуулалтын акт үйлдэж, 13,953,544,097.91 төгрөгийн зөрчилд 4,156,771,142.82 төгрөгийн нөхөн татвар, 1,247,941,687.13 төгрөгийн торгууль, 829,533,540 төгрөгийн алданги, нийт 6,234,246,369.95 төгрөгийн төлбөр төлүүлэхээр шийдвэрлэсэн.

2.2.Нэхэмжлэгч уг актыг эс зөвшөөрч нийслэлийн Татварын газрын дэргэдэх Маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан бөгөөд тус зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолоор нөхөн ногдуулалтын актыг хэвээр үлдээсэн байна.

3.Нэхэмжлэгчээс дараах үндэслэлээр маргаж байна. Үүнд:

3.1.“... Манай компани орлого олоогүй, алдагдалтай байхад алдагдлыг бууруулсан хэр нь бууруулсан дүнгээс нөхөн татвар, торгууль ногдуулсан нь үндэслэлгүй,

3.2.Хариуцагч нар нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлтийн дүнг бууруулж, баталгаажуулчхаад, бууруулсан дүнгээс нөхөн татвар, торгууль ногдуулсан нь үндэслэлгүй.

3.3.Хувьцаагаа шилжүүлсэн 2 хувьцаа эзэмшигчийн хооронд ямар ч орлого олсон, олгосон харилцаа үүсээгүй. Гэтэл манай компанид хувь хүнийг орлого олсон гэж үзээд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутгаж ногдуулсан нь хууль зөрчиж байна. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа компанийн хувьцааг аж ахуйн нэгж, компани биш хувь хүн эзэмшиж байсан. Хэрэв энэ хүмүүсийг хувьцаагаа зарж, орлого олсон гэж үзэж байгаа бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг биш, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого олсон гэж үзэж, тухайн хуулийн дагуу албан татвар ногдуулах ёстой. Гэтэл манайд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг үндэслэн татвар суутган төлөх үүрэгтэй гэж акт тавьсан нь үндэслэлгүй, хууль бус ...” гэжээ.

4.Хариуцагч нар нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч “Баримтаар нотлогдохгүй зардал алдагдлаас хассан, нэмэгдсэн өртгийн



албан татварын илүү төлөлтийг үндэслэлгүйгээр бууруулсан. Татварын ерөнхий хуульд “төлбөл зохих татварын дүнг 50 хувь хүртэл бууруулсан бол нөхөн төлөх татварын дүнгийн 30 хувиар торгоно” гэж заасны дагуу нөхөн татвар, торгууль ногдуулсан. Мөн “Мальфлюорит” ХХК нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч бөгөөд улсын бүртгэлд компанийн 75 хувийн хувьцаа эзэмшигчээр Р.Бадрах, 25 хувийн хувьцаа эзэмшигчээр Б.Ариунболд тус тус бүртгэгдэж, эцсийн хувьцаа эзэмшигч нь Р.Бадрах болж өөрчлөгдсөн. Иймд 2006 оны Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2, 16 дугаар зүйлийн 16.3.5, 17 дугаар зүйлийн 17.2.7, 21 дүгээр зүйлийн 21.7-д зааснаар тус компани нь шууд бусаар буюу хувьцаа шилжүүлэх замаар эрхийг хэсэгчлэн борлуулсан, шилжүүлсний орлогод албан татварыг ногдуулан суутган авч, төсөвт шилжүүлэх үүрэг хүлээнэ. Гэтэл уг үүргээ биелүүлээгүй, иймд хуулийн дагуу нөхөн ногдуулалтын акт гаргасан ...” гэж маргасан.

5. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 128/ШШ2025/0738 дугаар шийдвэрээр “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 1 дүгээр зүйлийн 1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.6, 5 дугаар зүйлийн 5.1, 8 дугаар зүйлийн 8.2, 21 дүгээр зүйлийн 21.5, 21 дүгээр зүйлийн 21.7, Татварын ерөнхий хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1, 84 дүгээр зүйлийн 84.1.5, Татварын ерөнхий (2008 оны) хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч нарын 2024 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн НА-22240000013 нөхөн ногдуулалтын актыг хүчингүй болгож” шийдвэрлэхдээ дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

5.1. “... Татварын улсын байцаагч нар Маягт ХШ11 “Мальфлюорит” ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангаар гарсан алдагдлыг ирээдүйд шилжүүлэн тооцож, алдагдлыг бууруулсан байна, ... албан татвар ногдох орлогоос хасагдах зардлыг хуульд заасан эдгээр шаардлагыг нэгэн зэрэг хангасан тохиолдолд хасаж төлөх татварыг бууруулахыг хуульд тодорхой заасан бөгөөд хангаагүй буюу албан татвар төлөгчийн албан татвар ногдох орлого олох үйл ажиллагаатай шууд холбогдон гараагүй зардлыг хасаж төлөх татварын хэмжээг бууруулсан талаар хариуцагчаас татвар ногдуулсныг буруутгахгүй боловч нэхэмжлэгч хуулийн этгээдийн тайлангаар гарсан алдагдлыг бууруулсан хэрнээ зөрүү алдагдал дүнгээс төлбөл зохих татварын дүнг 50 хүртэл хувиар бууруулсан бол нөхөн төлөх татварын дүнгийн 30 хувиар торгоно гэсэн заалтыг үндэслэн татвар ногдуулсан нь буруу. Учир нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 18 дугаар зүйлийн 18.1-д тодорхой хуульчилсан, иймд хариуцагч татварын улсын байцаагч нар алдагдлыг бууруулсан нь зөв боловч, алдагдалтай хуулийн этгээдийн алдагдлыг бууруулсан дүнгээс

төлбөл зохих татварын дүнг 50 хүртэл хувь бууруулсан гэх үндэслэлээр торгууль ногдуулсан нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн орлогод албан татвар ногдуулах гэсэн үндсэн зарчимд нийцээгүй.

5.2.Нэхэмжлэгч “Мальфлюорит” ХХК-ийн нэмэгдсэн өртгийн тайлангаар төсөвт төлөх татварын хэмжээг бууруулсан буюу төлөөгүй зөрчил гаргаагүй, харин төсвөөс буцаан авах илүү төлөлттэй гэж тайлагнасан. Гэтэл хариуцагч хувийн хэрэглээний худалдан авалтыг нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөл зохих татварын дүнгээс хасаж тооцон, төсвөөс буцаан авах нэмэгдсэн өртгийн албан татварыг өсгөсөн зөрчилд холбогдуулан тус компанийн төсвөөс буцаан авах илүү төлөлтийн дүнгээс нь хасаж, бууруулан баталгаажуулж, төсвөөс буцаан авах авлагыг хасах замаар зөрчлийг залруулсан атлаа, зөрүү дүнгээр дахин нөхөн төлбөр болон торгууль ногдуулсан нь үндэслэлгүй, нэхэмжлэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан байна.

5.3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 8 дугаар зүйлийн 8.2, 8.2.2-т зааснаас үзэхэд хариу төлбөртэйгөөр өөрийн эзэмшиж буй эрхээ шилжүүлснээр орлого олсон тохиолдолд татвар ногдуулахаар хуульчилсан ... Маргаан бүхий энэ тохиолдолд 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр 542 дугаартай бэлэглэлийн гэрээ, мөн өдрийн 543 дугаартай компанийн эрх шилжүүлэх тухай гэрээг тус тус үндэслэн, “Мальфлюорит” ХХК-ийн 50 хувийн хувьцааг 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 01/19 дүгээр хувьцаа эзэмшигчийн хурлын шийдвэрээр Б.Ариунболд нь өөрийн эзэмшлийн хувьцаанаас 50 хувийн хувьцааг бэлэглэлийн гэрээгээр тус компанийн 25 хувийн хувьцаа эзэмшигч Р.Бадрахад шилжүүлсэн нь орлого олсон гэх нөхцөлийг хангаагүй байх тул нэхэмжлэгчийг суутгагчийн үүргээ биелүүлээгүй гэж үзэх боломжгүй.

5.4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 5 дугаар зүйлийн 5.1-д зааснаар орлого олсон тохиолдолд татвар төлөх үүргийг хуульчилсан байхад бэлэглэлийн гэрээний оролцогч биш “Мальфлюорит” ХХК-ийг ашигт малтмалын тусгай зөвшөөлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар шууд бусаар орлого олсон гэж буруутгаж, хариуцагч татварын улсын байцаагч нар нөхөн ногдуулалтын актаар татвар ногдуулсан нь үндэслэлгүй ... Маргааны үйл баримтад холбогдуулан авч үзвэл, нэхэмжлэгч компани нь хэнд ч орлого олгоогүй тул дээрх хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д заасны дагуу суутгагч биш юм. Харин тус компани нь хувьцаа шилжүүлэх бэлэглэлийн гэрээний зүйл болсон тул татвар төлөгч болохгүй юм.

5.5.Хөөн хэлэлцэх хугацааны тухайд дараа оны буюу 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн тоолоход маргаан бүхий акт хөөн хэлэлцэх хугацаандаа байна ...” гэх зэргээр дүгнэжээ.



6.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 221/МА2026/0010 дугаар магадлалаар “Анхан шатны шүүхийн шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтад “... нэхэмжлэгч “Мальфлюорит” ХХК-ийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгож, нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагчийн 2024 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн НА-22240000013 нөхөн ногдуулалтын актаар ногдуулсан 6,234,246,369.95 төгрөгийн төлбөрийн хэмжээг 6,221,501,550.00 төгрөгөөр бууруулсан ...” өөрчлөлтийг оруулж шийдвэрлэхдээ дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

6.1.“... 2020 оны тайлангаар 16,678,216.70 төгрөг, 2021 тайлангаар 20,272,453.01 төгрөг, нийт 36,950,669.71 төгрөгийн үйл ажиллагааны орлого олохтой холбогдон гараагүй зардлаар татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцон хасалт хийсэн зөрчил гаргасан нь тогтоогдсон тул хариуцагч нараас энэ зөрчилд хариуцлага ногдуулсныг буруутгах үндэслэлгүй. Татварын улсын байцаагчид “Мальфлюорит” ХХК-ийн хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийг зөв тооцоолсон боловч актын хавсралт үйлдэхдээ мөр андууран техникийн алдаа гаргасан нь нөхөн төлүүлэх актын дүнд нөлөөлөхгүй, эрх зүйн байдлыг дордуулаагүй гэх хариуцагчийн тайлбар үндэслэлтэй. Өөрөөр хэлбэл, алдагдлыг бууруулсныг нэхэмжлэгч хүлээн зөвшөөрсөн энэ тохиолдолд алдагдалтай хуулийн этгээдийн алдагдлыг бууруулсан дүнгээс төлбөл зохих татварын дүнг 50 хүртэл хувиар бууруулсан гэж үзэн торгууль ногдуулсан нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.2, 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.1-д заасантай нийцсэн байна.

6.2.Нэхэмжлэгч нь 2021 онд 11,255,813.23 төгрөг, 2022 онд 79,778,614.97 төгрөгийн хувийн хэрэглээний худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг төлбөл зохих татварын дүнгээс хасаж төсвөөс буцаан авах татварын дүнг өсгөсөн нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.6.2-т заасныг зөрчсөн болох нь тогтоогджээ. Энэ тохиолдолд хариуцагчаас тухайн зөрчилд Татварын ерөнхий хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1-д зааснаар торгууль ногдуулж, нөхөн татвар төлүүлэхээр шийдвэрлэсэн нь үндэслэлтэй.

6.3.Хувьцааг шилжүүлэх үед үйлчилж байсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 5 дугаар зүйлийн 5.1, 8 дугаар зүйлийн 8.2, 8.2.2-т зааснаас үзэхэд хуулийн этгээд эсвэл түүний эцсийн эзэмшигч өөрийн эзэмшиж буй эрхээ бусдад шилжүүлснээр орлого олсон тохиолдолд татвар ногдуулах агуулгатай байна.

6.4.Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын агуулгыг тухайн аж ахуйн нэгж нь татвар төлөгч этгээдэд орлого олгосон буюу

шилжүүлсэн байх, ингэснээр тухайн аж ахуйн нэгж нь татварын орлогын хувьд албан татвар төлөгчийн төлөх ёстой татварыг суутган авч, төсөвт төлөх үүрэг хүлээхээр зохицуулсан гэж ойлгохоор байна. Үүнээс үзэхэд “Мальфлюорит” ХХК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7-д зааснаар ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эзэмшигч мөн боловч тус компани тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар шууд бусаар орлого олоогүй тул суутгагчийн үүрэг хүлээхгүй, хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч өөрийн хувьцаа, эсхүл хувь оролцоогоо бусдад шилжүүлсний үр дүнд тухайн компанийн эзэмшиж байсан газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн өмчлөгч солигдож байвал үүнээс олсон орлогод албан татвар ногдуулахаар хуульчилсан байхад нэхэмжлэгч компанийн хувь эзэмшигч нарын хооронд эрхээ шилжүүлсэн энэ тохиолдолд эрх борлуулсны орлогоос шууд бус орлого олсон гэж үзэх боломжгүй ...” гэжээ.

7.Хариуцагч нийслэлийн Татварын газрын татварын улсын байцаагч С.Эрдэнэцэцэг хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

7.1.“... 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Б.Ариунболд нь өөрийн эзэмшилд байсан 75 хувийн хувьцаанаас хувь оролцоогоо Р.Бадрахад шилжүүлсэн. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эрх эзэмшигч “Мальфлюорит” ХХК-ийн эцсийн эзэмшигч буюу тус компанийн 75 хувийн хувьцаа эзэмшигч иргэн Б.Ариунболд нь өөрийн эзэмшлийн хувьцааны 50 хувь болох 13,825,559,000.00 төгрөгийн үнэлгээтэй хувьцааг компанийн 25 хувийн хувьцаа эзэмшигч Р.Бадрахад 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр хувьцаа бэлэглэх гэрээ байгуулан шилжүүлж, улмаар Б.Ариунболд 25 хувь, Р.Бадрах 75 хувийн хувьцаа эзэмшигч болж, компанийн эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн.

7.2.Хэрэв тус компани нь төрийн байгууллагаас олгосон эрх эзэмшдэггүй байсан тохиолдолд анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт, магадлал үндэслэлтэй байх байсан. Харин маргааны үйл баримтад хамаарах цаг хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж байсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 8 дугаар зүйлийн 8.2.2-т “хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар ... ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон орлого” нь эрх борлуулсны орлогод хамаарч, албан татвар ногдох бөгөөд дээрх хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.5-д зааснаар эрх борлуулсны орлогын нийт дүнгээр татвар ногдуулах орлогыг тодорхойлж, 17 дугаар зүйлийн 17.2.7-д заасны дагуу эрх борлуулсны орлогод 30 хувиар албан татвар ногдуулах, зохицуулалтыг зөрчиж, албан татварыг төсөвт төлөөгүй болох нь хяналт шалгалтаар илэрсэн. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 16 дугаар зүйлийн 16.11, 16.14, Сангийн сайдын 2017



оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 380 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, тусгай зөвшөөрөл шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах аргачлал”-ын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч “Мальфлюорит” ХХК-ийн эцсийн эзэмшигч Б.Ариунболдын бусдад шилжүүлсэн 50 хувийн хувьцаанд ногдох хэмжээгээр тусгай зөвшөөрлийн үнэлгээнээс хувь тэнцүүлэн тооцож албан татвар ногдуулах орлогыг тодорхойлж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь заалтаар тус компани нь шууд бусаар буюу хувьцаа шилжүүлэх замаар эрхийг хэсэгчлэн борлуулсан, шилжүүлсний орлогод албан татварыг ногдуулан суутган авч төсөвт шилжүүлэх үүргээ биелүүлээгүй.

7.3.Хэдийгээр татварын улсын байцаагч зөрчлийг илрүүлж, актын үндэслэх хэсэгтээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) зөрчигдсөн хууль тогтоомжийг зөв хэрэглэсэн боловч хэрэглэвэл зохих хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсгийг дутуу баримталсныг анхан шатны шүүхээс хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгээр суутгагч этгээдэд хамаарахгүй болон Улсын дээд шүүхийн хамааралгүй тогтоолыг дурдаж актын холбогдох хэсгийг хүчингүй болгосон нь үндэслэлгүй. Хуулийн дээрх заалтууд болон үйл баримтуудаас үзвэл “Мальфлюорит” ХХК нь 2019 онд иргэн Б.Ариунболдоос 50 хувийн эзэмших эрхийг шилжүүлж авахдаа албан татвар ногдуулан суутган авч, төсөвт төлөөгүй зөрчил гаргасан нь тогтоогдсон байх тул энэ үндэслэлээр тус компанид нөхөн төлбөр ногдуулсан нь хуульд нийцсэн.

7.4.Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 8 дугаар зүйлийн 8.2.2-т “хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар ...ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн эцсийн эзэмшигчийн хувьцаа хувь оролцоог нэмэгдүүлэх замаар олсон орлого”-ыг эрх борлуулсны орлогод хамааруулахаар заасан, “Мальфлюорит” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хувь оролцоо нэмэгдэж, нөгөө талдаа буурах замаар хийгдсэн шилжилт хөдөлгөөнийг Татварын ерөнхий газарт бүртгүүлээгүй, албан татвар ногдуулан төсөвт төлөөгүй нь тогтоогдож байна. Өөрөөр хэлбэл, Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасанчлан “Мальфлюорит” ХХК-ийн 50 хувийн хувьцааг Б.Ариунболдоос Р.Бадрахад шилжүүлж байгаа нь холбогдох гэрээ бүртгэлээр үүссэн, нөгөө талаар компани нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ба тухайн компанийн эзэмшлийн хувьцааг шилжүүлснээрээ эрх борлуулсан орлого олсон үйлдэлд хамаарна.

7.5.Түүнчлэн, Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д зааснаар хувьцаа нь хувьцаа эзэмшигчийн тухайн компанийн хувьд эдлэх эрхийг илэрхийлэхийн хувьд 50 хувь хувьцааны эрх шилжүүлсэн үйлдлийг

эрх борлуулсан гэж үзэхээр байна. Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүхээс эрх борлуулсны орлогод татвар ногдуулахад эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг бусдад төлбөртэй шилжүүлж, үүний улмаас орлого олсон байх, мөн “Мальфлюорит” ХХК нь хэнд ч орлого олгоогүй тул суутгагч биш, орлого олсон этгээд нь аж ахуйн нэгж биш, түүнчлэн эцсийн эзэмшигч өмчлөгч өөрчлөгдсөн байх гэсэн нөхцөлийг хангаагүй гэх байдлаар дүгнэж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй юм.

7.6.Өөрөөр хэлбэл, дээрх компани нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч бөгөөд улсын бүртгэлд компанийн 75 хувийн эзэмшигчээр Р.Бадрах, 25 хувийн хувьцаа эзэмшигчээр Б.Ариунболд тус тус бүртгэгдэж эцсийн хувьцаа эзэмшигч нь Р.Бадрах болж өөрчлөгдсөн. “Эцсийн эзэмшигч” гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг” гэж хуульд заасан, гэтэл анхан болон давж заалдах шатны шүүх “ ... нэхэмжлэгч компанийн хувь эзэмшигч нарын хооронд эрхээ шилжүүлсэн байхад эрх борлуулсны орлогоос шууд бус орлого олсон гэж үзэх боломжгүй ...” гэж хуулийг буруу тайлбарлаж, хууль дээдлэх, хуулийн өмнө тэгш байх, хуульд үндэслэх зарчмыг зөрчиж байна.

7.7.Мөн тус компанийн 2019 оны санхүүгийн баталгаажсан тайланд 1.1.2.дансны авлага 5,000.0 сая төгрөг, 1.1.4.бусад авлага 19,217.1 сая төгрөг, 2.3.9.хуримтлагдсан ашиг 24,477.2 сая төгрөг гэсэн байна. Тайлангийн тодруулга хэсгийн 4.1.Богино хугацаат авлага 1.Холбоотой талаас авах авлагын тайлант хугацаанд хамаарах дүн 19,217.1 сая төгрөг тайлагнасан байна. Өөрөөр хэлбэл, эрх шилжсэнтэй холбоотой тооцооны авлага, өглөгийг баталгаажуулсан байна. Одоо мөрдөгдөж байгаа хуулийн хүрээнд эцсийн эзэмшигч өөрчлөгдөж байгаа тохиолдолд бүх татвар төлөгч нар нь Татварын ерөнхий газрын Том татвар төлөгчийн газрын Эрдэс баялгийн хэлтэст албан хүсэлт өгч, татварын тооцоолол хийсний дараа татвараа төлсөн тодорхойлолт авч Улсын бүртгэлийн газар шилжилт хийлгэж бүрдүүлдэг. Харин “Мальфлюорит” ХХК-ийн хувьд ийм үйлдлийг хийгээгүй бөгөөд татвар төлөлгүй бүртгэл хийлгэж шилжүүлсэн байгаа. Энэ талаар Аудитын ерөнхий газраас ирсэн албан бичиг мэдэгдэлд дурдсан. Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаар татвар бий болгох, тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хяналт шалгалт хийх, хураах, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд баримтлах зарчим нь “зайлшгүй байх”, “тодорхой байх”, “шударга байх”, “үр ашигтай байх” гэж заасан тул нэхэмжлэгчийн хууль зөрчсөн үйлдлийг зөвтгөх үндэслэл болохгүй.



7.8.Иймд зөрчил нэгэнтээ үйлдэгдсэн тул татвар зайлшгүй байх, шударга байх зарчмыг баримтлан нөхөн ногдуулсан актыг хэвээр үлдээж, шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож өгнө үү” гэжээ.

8.Нэхэмжлэгч тал “хариуцагчийн гомдол үндэслэлгүй, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж өгнө үү” гэсэн агуулгатай тайлбарыг өгөв.

9.Хяналтын шатны шүүх хариуцагчийн гомдлыг “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн” үндэслэл байгаа эсэхийг хянан хэлэлцэхээр хүлээн авсан болно.

ХЯНАВАЛ:

10.Хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг дараах үндэслэлээр хангах боломжгүй байна.

11.Энэ хэргийн тухайд, “хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн” гэх үндэслэл тогтоогдсонгүй, харин шүүхүүд хуулиар тусгайлан заасан татварын хөөн хэлэлцэх хугацааны талаарх зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэсэн байх тул хяналтын шатны шүүхээс энэ талаарх “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах” шаардлага үүссэн гэж үзлээ.

12.Хариуцагч нар маргаан бүхий 2024 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн НА-22240000013 дугаар нөхөн ногдуулалтын актаар нэхэмжлэгч “Мальфлюорит” ХХК-ийг дараах 3 зөрчлийг гаргасан гэж буруутган, нийт 6,234,246,369.95 төгрөгийн нөхөн татвар, торгууль, алданги ногдуулсан байна. Үүнд:

Нэгд.2020 онд 16,678,216.70 төгрөг, 2021 онд 20,272,453.01 төгрөг, нийт 36,950,669.71 төгрөгийн үйл ажиллагааны орлого олохтой холбогдон гараагүй зардлаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлангийн татвар ногдох орлогоос хасагдах зардалд тооцон хасалт хийж татвар ногдуулах орлогыг бууруулсан үйлдэл нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.1.2, 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.1 дэх заалтыг зөрчсөн тул 1,575,813.85 төгрөгийн;

Хоёрт.2021 онд 11,255,813.23 төгрөг, 2022 онд 79,778,614.97 төгрөг, нийт 91,034,428.20 төгрөгийн хувийн хэрэглээний худалдан авалтыг нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөл зохих татварын дүнгээс хасаж тооцон, төсвөөс буцаан авах нэмэгдсэн өртгийн албан татварыг өсгөсөн үйлдэл нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6, 14.6.2 дахь заалтыг зөрчсөн тул 11,169,006.10 төгрөгийн;

Гуравт.2019 онд “Мальфлюорит” ХХК-ийн эцсийн эзэмшигч Б.Ариунболд нь өөрийн эзэмшилд байсан 75 хувийн хувьцаанаас 50 хувь болох 13,825,559,000.00 төгрөгийн үнэлгээтэй хувьцаа, хувь оролцоо болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн эрхийг хувьцаа эзэмшигч Р.Бадрахад шилжүүлэх замаар эцсийн эзэмшигч өөрчлөгдөхөд компани нь татвар суутган тооцож, суутгагчийн үүргээ биелүүлээгүй нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 8 дугаар зүйлийн 8.2.2, 16 дугаар зүйлийн 16.3.5, 17 дугаар зүйлийн 17.2.7, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалтыг зөрчсөн тул 6,221,501,550.00 төгрөгийн нөхөн татварыг тус тус ногдуулжээ.

13.Нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсэг буюу маргаан бүхий актын 1 болон 2 дахь хэсгийг хүчингүй болгуулах шаардлагыг хэрэгсэхгүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалд нэхэмжлэгч тал гомдол гаргаагүй тул хүлээн зөвшөөрсөнд тооцно. Хариуцагчаас нөхөн ногдуулалтын актын 3 дахь хэсгийг хүчингүй болгосон шүүхийн шийдвэр, магадлалд холбогдуулан гомдол гаргасан тул хяналтын шатны шүүх энэ хүрээнд дүгнэлт өгнө.

14.Нэхэмжлэгчээс 2024 оны НА-22240000013 дугаар нөхөн ногдуулалтын актын 3 дахь хэсгийг хэд хэдэн үндэслэлээр хууль бус гэж маргасны дотор хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой үндэслэлийг заасан байна. Анхан шатны шүүх энэ талаар дүгнэхдээ “... Татварын ерөнхий хуулийн (2019 оны) 15 дугаар зүйлийн 15.3.2-т “тайланг сар, улирлаар гаргаж татвар төлөхөөр хуульд заасан татварын төрлийн хувьд тухайн жилийн 12 дугаар сарын буюу жилийн эцсийн тайлан гаргаж, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс”, ... гэж заасан. Түүнчлэн, Татварын ерөнхий газрын даргын 2018 оны А/63 дугаар тушаалаар баталсны дагуу суутгагчийн аж ахуйн нэгжид олгосон орлогоос суутгасан албан татварын тайланг оны эхнээс өссөн дүнгээр улирлаар тайлагнахаар зохицуулсан. Тодруулбал, суутгагчийн аж ахуйн нэгжид олгосон орлогоос суутгасан албан татварын тайланг улирлаар гаргаж татвар төлөх татварын төрлийн хувьд тухайн жилийн 12 дугаар сарын буюу жилийн эцсийн тайлан гаргаж, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг тоолохоор тусгайлан журамлажээ. Хөөн хэлэлцэх хугацааны тухайд дараа оны буюу 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн тоолоход маргаан бүхий акт хөөн хэлэлцэх хугацаандаа байна ...” гэж хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн нь буруу байхад үүнийг давж заалдах шатны шүүхээс залруулаагүй байна.

15.Учир нь, маргааны үйл баримтад хэрэглэгдэх (2006 оны) Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд хууль тогтоогчоос 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Үүнийг тодруулбал, уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.2-т “хуулийн этгээд, түүний эцсийн эзэмшигч хувьцаа, хувь оролцоогоо бусдад шилжүүлэх замаар газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн



эцсийн эзэмшигчийг өөрчлөх замаар олсон орлого"-ыг аж ахуйн нэгжийн эрх борлуулсны орлогод хамааруулж (8 дугаар зүйлийн 8.2), 4 дүгээр зүйлийн 4.1.8-д "эцсийн эзэмшигч"-ийг тодорхойлсон. Ийнхүү татварын шинэ төрлийг бий болгосонтой холбоотойгоор 16 дугаар зүйлийн 16.11 болон 16.12-т тухайн орлогыг яаж тооцох, албан татвар ногдуулах орлогыг хэрхэн тодорхойлох талаар, мөн зүйлийн 16.13, 16.14-т тухайн орлогыг болон татварын ногдлыг тодорхойлох аргачлал батлах үүргийг эрх бүхий этгээдэд шилжүүлсэн.

16.Энэхүү хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд 21 дүгээр зүйлийн 21.7-д "Энэ хуулийн 16.11, 16.12, ... -т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулах албан татварыг тухайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл газар эзэмших, ашиглах эрхтэй этгээд хэлцэл хийгдсэнээс хойш ажлын 7 хоногийн дотор ногдуулан суутган авч, төсөвт шилжүүлнэ" гэсэн заалтыг нэмжээ.

17.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 21 дүгээр зүйлийн 21.5 болон 21.6 дахь хэсэгт тухайлан заасан орлогод ногдох албан татварыг суутгагч ногдуулан суутган авч, ажлын 7 болон 10 хоногийн дотор төсөвт шилжүүлэх тухай дээрх хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7-д заасантай төсөөтэй агуулга бүхий зохицуулалт байх боловч уг зүйлийн 21.8-д "Суутгагч нь энэ хуулийн 21.5, 21.6-д зааснаар суутгасан албан татварын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор улирал бүр өссөн дүнгээр, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор гаргаж, харьяалах татварын албанд тушаана" гэж заасан. Өөрөөр хэлбэл, хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсэгт 21.7 дахь хэсэг хамаарахгүй буюу шинээр бий болсон татварыг (8.2.2 буюу 16.11, 16.12-т зааснаар тодорхойлох) тайлагнах хугацааг хуульд тодорхой заагаагүй байна.

18.Түүнчлэн, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 21 дүгээр зүйлийн 21.8-д заасан "суутгагч" нь мөн хуулийн 4.1.6-д заасан "албан татвар төлөгчид олгосон орлогод албан татвар ногдуулан суутгаж, төсөвт шилжүүлэх үүрэг бүхий этгээд" бол, 21.7-д заасан "суутган төлөгч" нь бусад татвар төлөгчид олгосон орлогоосоо татвар ногдуулан суутган төлөгч бус, харин ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл газар эзэмших, ашиглах эрхтэй этгээд байгаагаараа ялгаатай байна.

19.Энэ тохиолдолд Татварын ерөнхий хуулийн (2008 оны) 43 дугаар зүйлийн 43.5-д "Татварын тайлан тушаах, төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтоох ба татвар төлөх, тайлагнах эцсийн хугацаа адил байна"¹ гэсэн ерөнхий зохицуулалт үйлчилнэ. Өөрөөр хэлбэл,

¹ 2019 оны Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т "Татварын тайлан тушаах, татвар төлөх хугацааг тухайн төрлийн татварын хуулиар тогтоох бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол татвар төлөх, тайлагнах хугацаа адил байна." гэж заасан.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 21 дүгээр зүйлийн 21.7-д татвар төлөх хугацааг тусгайлан зохицуулсан бөгөөд энэ нь тухайн хуульд заасан (бусад) татварын тайлан гаргах хугацаанд хамаарахгүй байх тул “татвар төлөх болон тайлагнах хугацаа адил байх” Татварын ерөнхий хуулийн нийтлэг зохицуулалт үйлчилнэ.

20.Иймд, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 8 дугаар зүйлийн 8.2.2-т буюу 16 дугаар зүйлийн 16.11, 16.12-т заасны дагуу тодорхойлсон орлогод ногдуулах албан татварыг тухайн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, эсхүл газар эзэмших, ашиглах эрхтэй этгээд хэлцэл хийгдсэнээс хойш ажлын 7 хоногийн дотор суутган авч төсөвт шилжүүлнэ, мөн хугацаанд тайлагнана” гэж хэрэглэх нь зүйтэй.

21.Хөөн хэлэлцэх хугацааны тухайд, татварын акт гарах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Татварын ерөнхий хуулийн зохицуулалт үйлчлэх зарчимтай. Үүнийг Татварын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн агуулга (тухайлбал, 7 дугаар зүйл)-аас харж болно.

22.Маргаан бүхий актыг гарах үед буюу одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2019 оны Татварын ерөнхий хуулийн /Шинэчилсэн найруулга/ 15 дугаар зүйлийн 15.1-д “Татварын нөхөн ногдуулалт хийх, алданги, торгууль ногдуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, алдагдал шилжүүлэх, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хөөн хэлэлцэх хугацаа 4 жил байх...”-аар, 15.3-т “Энэ хуулийн 15.1-д заасан хугацааг дараах байдлаар тоолно:”, 15.3.3-т “борлуулалт хийгдсэнээс хойш тодорхой хугацааны дотор татвар төлөхөөр хуульд заасан татварын төрөл болон суутгаж төлдөг татварын хувьд тухайн төрлийн татварын тайланг гарган, татвараа төлж дууссан байх ёстой өдрийн дараагийн ажлын өдрөөс” гэж тус тус заасныг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 21 дүгээр зүйлийн 21.7 дахь хэсэгтэй холбон тайлбарлавал, маргаан бүхий актын 3 дахь хэсгийн хувьд хөөн хэлэлцэх хугацаа дууссан байна.

23.Тодруулбал, хэрэгт авагдсан баримтаар татварын хяналт шалгалтын хүрээнд албан татвар нөхөн ногдуулах үндэслэлийг бий болгосон гэх нэхэмжлэгч компанийн 50 хувийн хувьцаа бэлэглэлийн гэрээ нь 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хооронд байгуулагдаж, 2019 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн болох нь тогтоогдсон. Энэ хугацаанаас хойш хуульд заасан ажлын 7 хоногийг тооцон үзвэл, татвар төлөх болон тайлагнах эцсийн хугацаа нь 2019 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр байна. Үүнээс хойш татварын нөхөн ногдуулалт хийх, алданги, торгууль ногдуулах 4 жилийн хөөн хэлэлцэх хугацааг тоолоход, 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр дуусжээ. Гэтэл хариуцагч нар маргаан бүхий



НА-22240000013 дугаар татварын нөхөн ногдуулалтын акт (3 дахь хэсэг)-ыг 2024 оны 2 дугаар сарын 09-ний өдөр буюу хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн хойно гаргасан нь хууль бус, энэ үндэслэлээр нэхэмжлэлийн холбогдох шаардлагыг хангах үндэслэлтэй.

24.Иймд, маргаан бүхий актын 3 дахь хэсгийг хүчингүй болгосон шүүхүүдийн шийдэл зөв байх тул хариуцагчийн гомдлыг хангахгүй орхиж, магадлалд хууль хэрэглээний өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзэв.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 221/МА2026/0010 дугаар магадлалын Тогтоох хэсгийн 1 дэх заалтын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 1 дүгээр зүйлийн 1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.6, 5 дугаар зүйлийн 5.1, 8 дугаар зүйлийн 8.2, 21 дүгээр зүйлийн 21.5, 21 дүгээр зүйлийн 21.7, Татварын ерөнхий хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1, 84 дүгээр зүйлийн 84.1.5, Татварын ерөнхий (2008 оны) хуулийн 74 дүгээр зүйлийн 74.1 дэх ...” гэснийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн (2006 оны) 21 дүгээр зүйлийн 21.7, Татварын ерөнхий хуулийн (2008 оны) 43 дугаар зүйлийн 43.5, Татварын ерөнхий хуулийн /2019 оны Шинэчилсэн найруулга/ 15 дугаар зүйлийн 15.1, 15.3.3 дахь ...” гэж өөрчилж, магадлалын бусад хэсгийг хэвээр үлдээж, хариуцагч С.Эрдэнэцэцэгийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар хариуцагч тэмдэгтийн хураамж төлөөгүйг дурдсугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН
ШҮҮГЧИД**

**Д.МӨНХТУЯА
Д.БАТБААТАР
П.СОЁЛ-ЭРДЭНЭ
Г.БАНЗРАГЧ**

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ
ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 03 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар: 001/ХТ2026/0030

Улаанбаатар
хот

**Т.Батцэцэгийн нэхэмжлэлтэй,
Монополын эсрэг газрын даргад
холбогдох захиргааны хэргийн тухай**

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:

Танхимын тэргүүн:

Шүүгчид:

Илтгэгч шүүгч:

Нарийн бичгийн дарга:

Ц.Цогт

Д.Мөнхтуяа

Г.Банзрагч

М.Батсуурь

П.Соёл-Эрдэнэ

Б.Зэнээмэдрээ

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны
09 дүгээр сарын 09-ний өдрийн 128/ШШ2025/0615 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны
11 дүгээр сарын 04-ний өдрийн 221/МА2025/0698 дугаар магадлалтай,

Хэргийн оролцогчид: Нэхэмжлэгчийн өмгөөлөгч Ж.Очирхуяг,
хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгч А.Базар нарыг
оролцуулан,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт
шүүгчийн хуралдааны 2026 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 66 дугаар
хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг
арилгах” эсэх, “хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр
хэрэглэсэн” эсэх гэсэн үндэслэлээр, нэхэмжлэгчийн хяналтын журмаар
гаргасан гомдлыг хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага: Урьд эрхэлж байсан Монополын
эсрэг газар (хуучин нэрээр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө
газар)-ын Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын
даргын албан тушаалд эгүүлэн томилохгүй байгаа эс үйлдэхүй хууль бус
болохыг тогтоолгож, томилохыг даалгах, ажилгүй байсан хугацааны цалин
хөлстэй тэнцэх олговрыг гаргуулах, эрүүл мэнд, нийгмийн даатгалын
шимтгэлийг нөхөн төлүүлэх, дэвтэрт нөхөн бичилт хийхийг даалгах;



2.Хэргийн нөхцөл байдал: Т.Батцэцэг нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын (хуучин нэрээр) Өрсөлдөөний бодлого, зохицуулалтын газрын даргын албан тушаалд ажиллаж байхдаа Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газрын гэрээ, хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа ЖАЙКА-ийн “Legal and Judicial Human Resources Development” (хууль, эрх зүйн хүний нөөцийг хөгжүүлэх) тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэн, Япон Улсын Кобэ их сургуулийн Хууль, эрх зүйн магистрын хөтөлбөрт 2022 оны 10 дугаар сараас 2024 оны 09 дүгээр сар хүртэл суралцаж, төгссөн байх бөгөөд урьд эрхэлж байсан ажилдаа орж чадаагүй байна.

3.Нэхэмжлэгчээс “... эрхэлсэн ажилдаа мэргэшин суралцах зорилгоор захиргааны байгууллагатай буцаж ажилдаа орох гэрээ байгуулан төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, уг гэрээгээр сургуулиа төгссөний дараа тухайн байгууллагадаа 3-аас доошгүй жил үргэлжлүүлэн ажиллах үүрэг хүлээсэн, гэтэл хариуцагч ажлын байранд эгүүлэн томилж ажиллуулах үүргээ өнөөдрийг хүртэл биелүүлэхгүй эс үйлдэхүй гаргаж байна, ажил олгогчийн зөвшөөрсөн хугацаагаар сургалтад хамрагдаж байгаа бол ажлын байрыг хэвээр хадгалж, түр орлон гүйцэтгэгч томилох зохицуулалтыг хэрэглэх ёстой, сонгон шалгаруулалтад орж Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлсэн тохиолдолд ажлын байраар хангана гэдэг нь миний эрх зүйн байдлыг дордуулж байна, тухайн албан тушаалын шалгуур, болзол нөхцөлийг хангасан төрийн жинхэнэ албан хаагч нь нэг албан тушаалд хоёр удаа Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлэх боломжгүй” гэж,

4.Хариуцагчаас “... нэхэмжлэгч төрийн албанаас түр чөлөөлөгдсөн учраас төрийн албан хаагчийн нөөцөд байгаа гэж тооцогдоно, нөөцөд бүртгэлтэй иргэнийг сонгон шалгаруулж төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлсэн нөхцөлд томилохоор байна, хариуцагч захиргааны байгууллага шийдвэрлээгүй орхигдуулсан зүйл байхгүй, шийдвэрлээд татгалзсан хариу өгсөн, эс үйлдэхүй болон татгалзсан шийдвэртэй холбоотой шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа хэтрүүлсэн, төрийн албаны нөөцөд байгаа бусад иргэнээс нэхэмжлэгч ямар нэгэн давуу эрх эдэлж, шалгалт өгөхгүйгээр шууд томилогдох эрхгүй” гэж тус тус маргажээ.

5.Анхан шатны шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Үүнд:

5.1.Төрийн албан хаагч 3 сараас дээш хугацаагаар сургалтад хамрагдахаар болсон тохиолдолд түүнийг төрийн албанаас түр чөлөөлөхөөр, ийнхүү чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн албаны нөөцөд байгаад тооцохоор хуульчилжээ.

5.2.Нэхэмжлэгч Т.Батцэцэг нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/110 дугаар тушаалаар Япон Улсад магистрын сургалтад хамрагдах болсон шалтгаанаар төрийн албанаас түр чөлөөлсөн тул түүнийг төрийн албаны нөөцөд байгаад тооцохоор байна. Хариуцагчаас ийнхүү шийдвэрлээгүй орхигдуулсан хууль бус эс үйлдэхүй гаргасан гэж үзэхээргүй байна.

5.3.Төрийн албаны зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 02/2657 дугаар албан бичгээр Т.Батцэцэгт гаргасан гомдлыг дахин шийдвэрлэх боломжгүй тухай хариу өгсөн байгаагаас Т.Батцэцэг шүүхэд нэхэмжлэл гаргах хугацаагаа хэтрүүлсэн гэх нөхцөл байдал тогтоогдож байгаа хэдий ч хэргийн үйл баримтад дүгнэлт хийж, нэхэмжлэлийг эцэслэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэв.

6.Давж заалдах шатны шүүх дараах үндэслэлээр шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн. Үүнд:

6.1.Нэхэмжлэгч Т.Батцэцэгийн хувьд Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр магистрын хөтөлбөрт хамрагдах үндэслэлээр ажлаас чөлөөлсөн Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн Б/110 дугаар тушаалтай маргаагүй бөгөөд тэрээр 3 сараас дээш хугацааны сургалтад буюу Legal and Judicial Human Resources Development хөтөлбөрийн 2022-2024 оны магистрын сургалтад суралцахаар төрийн албанаас түр чөлөөлөгдсөн байх тул түүнийг төрийн албан хаагчийн нөөцөд байгаад тооцохоор байна.

6.2.Хэдийгээр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн суралцагчтай байгуулсан гэрээнд буцаж ирсэн оюутныг нэн даруй ажлын байраар хангаж, суралцахаас өмнөх албан тушаалаас нь зэрэглэл бууруулахгүйгээр ажлын байраар хангаж 3 ба түүнээс дээш жил ажиллуулахаар заасан хэдий ч Төрийн албаны тухай хуульд нийцүүлэх талаар тусгасан, харин дээр дурдсан Төрийн албаны тухай хуулийн зохицуулалтаас үзэхэд төрийн албан хаагч гурван сараас дээш хугацаагаар ямар нэгэн сургалтад хамрагдах бол түүнийг төрийн албанаас түр чөлөөлөхөөр, ийнхүү чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн албаны нөөцөд байгаад тооцох, улмаар төрийн албаны сул орон тоог нөхөхдөө шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон мөн хуульд заасан нөөцөд байгаа иргэдээс нөхөхөөр заасан хуулийг хариуцагч хэрэгжүүлэх үүрэгтэй, энэ хүрээнд хариуцагчаас төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэдийг сонгон шалгаруулж Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлсэн нөхцөлд ... зохих журмын дагуу ажлын байраар хангах боломжтой гэсэн хариуг нэхэмжлэгчид хүргүүлснийг шүүх хууль бус гэж үзэх боломжгүй байна.



7.Нэхэмжлэгч хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

7.1.Хоёр шатны шүүх сул орон тоо гарсан гэж тусгай шалгалтыг авч Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлсэн нөхцөлд урьд эрхэлж байсан албан тушаалд эгүүлэн томилох ёстой гэх агуулгаар дүгнэлт хийж хэргийг шийдвэрлэсэн нь дээд шүүхийн тогтоол, тайлбараас тухайн хуулийн заалтыг өөрөөр хэрэглэсэн нь шүүхийн хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг үүсгэж байна.

7.2.Монгол Улсын дээд шүүхийн 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 001/ХТ2024/0029 дүгээр тогтоолоор “бүр чөлөөлөгдсөн иргэний хувьд дахин төрийн албанд ажиллах хүсэлтэй бол төрийн албаны шалгалтыг өгч, эхнээс нь эхлэх бол, харин түр чөлөөлөгдсөн иргэний хувьд төрийн албаны нөөцөд байх хугацаанд сул орон тоо гарсан тохиолдолд өөрийн ажиллаж байсан албан тушаалын ангилал, олгогдсон зэрэг дэвийн дагуу эргэн томилогдох боломжтой байна” гэх тайлбарыг хийж маргааныг эцэслэн шийдвэрлэсэн байдаг. Т.Батцэцэгийн урьд ажиллаж байсан албан тушаалын ангилал зэрэглэл өөрчлөгдөөгүй.

7.3.Тухайн албан тушаалын шалгуур, болзол нөхцөлийг хангасан төрийн жинхэнэ албан хаагч нь нэг албан тушаалд хоёр удаа Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлэх шаардлага Төрийн албаны тухай хуулиар байх боломжгүй юм. Иймээс хариуцагчийн эс үйлдэхгүй хууль бус болох нь үүгээр илэрхий нотлогдож байхад шүүхээс хэргийн үйл баримтыг буруу дүгнэж шийдвэрээ гаргасан.

7.4.Япон Улсын Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн суралцагчтай байгуулах гэрээ нь Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.2.1-д заасан Төрийн албаны эрх зүйн харилцааны хүрээнд гарсан захиргааны акт юм. Нэхэмжлэгч гэрээний үүргээ биелүүлж Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн газрын чиг үүрэгт хамаарах мэргэшлийг эзэмшиж төгссөн бөгөөд хариуцагч гэрээний үүргээ биелүүлж, миний ажлын байрыг хадгалах, эгүүлэн томилох үндсэн үүргээ биелүүлэхгүй байгаа нь эс үйлдэхүй мөн.

7.5.Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтыг буюу “сул орон тоо” гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг” гэсэн тайлбарыг өмгөөлөгч гаргасан бөгөөд шүүх дээрх хуулийн зохицуулалтуудын хууль зүйн үндэслэлийг няцаалгүй шийдвэрээ гаргасан.

7.6.Хөдөлмөрийн тухай хуулийн “... урт хугацааны сургалтад хамрагдах зорилгоор төрийн албанаас түр чөлөөлөгдсөн төрийн албан

хаагчийн ажлын байрыг хадгалах”-тай холбоотой хуулийн зохицуулалтыг шүүх тухайн маргааныг шийдвэрлэхдээ хамааралтай талаас нь хэрэглээгүй.

7.7.Монополын эсрэг газрын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 01/2066 дугаар албан бичгийг хэзээ хойно даргатай нь хэд хэдэн удаа уулзаж итгэл төрүүлж, хугацаа өнгөрсний дараа 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр “Монгол шуудан” ХК-д шуудангаар хүргүүлж байгаа нь хууль бус эс үйлдэхүйтэй нь шууд холбоотой байхад энэхүү үйл баримтыг мөн хэрэгт хамааралтай, ач холбогдолтой талаас нь шүүх дүгнээгүй.

8.Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгч тайлбартаа:

8.1.Нэхэмжлэгч 6 сараас дээш хугацааны сургалтаар бэлтгэгдэх болсон үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн хүн нь төрийн албан хаагчийн нөөцөд байгаад тооцогдоно. Энэ талаар шүүхүүд зөв дүгнэсэн.

8.2.Улсын дээд шүүхийн тогтоолыг эш татсан ч Улсын дээд шүүхийн зүгээс төрийн албанаас түр чөлөөлөгдсөн энэ тохиолдолд төрийн албаны нөөцөд байна гэж тайлбарласан. Төрийн албаны нөөцөд байгаа иргэн нь тусгай шалгалт өгч байж томилогдох хуулийн зохицуулалттай талаар тодорхой тайлбарласан. Нэхэмжлэгч нь хяналтын гомдолдоо үүнийг няцааж тайлбар бичээгүй.

8.3.Хариуцагчаас нэхэмжлэгчийн өргөдлийг шийдвэрлэж маргаан бүхий төрийн албанд тусгай шалгалтгүйгээр томилох боломжгүй талаарх хариу өгсөн байхад энэ шийдвэртэй маргаагүй, хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гаргаагүй. Хариуцагчийг эс үйлдэхүй гаргасан гэж маргаж байгаа нь үндэслэлгүй.

ХЯНАВАЛ:

9.Анхан болон давж заалдах шатны шүүхээс хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байх тул шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, гомдлыг хангаж шийдвэрлэлээ.

10.Энэ хэргийн тухайд хяналтын шатны шүүхээс хууль зүйн дүгнэлт өгөх шаардлагатай асуудал нь Засгийн газрын тэтгэлгээр урт хугацаагаар гадаад улсад суралцсан тохиолдолд урьд нь эрхэлж байсан албан тушаалыг хадгалах, эгүүлэн томилох үүрэг захиргаанд ногдох эсэх тухай байна.



11.Тогтоогдсон үйл баримтын тухайд, Т.Батцэцэг нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын, Өрсөлдөөний бодлого, зохицуулалтын газрын даргаар ажиллаж байгаад Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Засгийн газар хоорондын байгуулсан гэрээний дагуу, Япон Улсын Засгийн газраас зарласан тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэж, Кобэ их сургуулийн хуулийн магистрт суралцахаар болсон, 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Т.Батцэцэг нарын хооронд суралцах гэрээ байгуулагдаж, нэхэмжлэгч 2022 оны 10 сараас 2024 оны 9 сар хүртэл суралцаж төгсөн ирсэн боловч хариуцагч урьд эрхэлж байсан албан тушаалд нь буцаан томилоогүй байна.

12.Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т ““сул орон тоо” гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг ойлгоно” гэж заасныг маргааны үйл баримтад холбогдуулан тайлбарлахад, нэхэмжлэгч Т.Батцэцэг нь байгууллагын зөвшөөрлөөр, Япон Улсын Засгийн газрын тэтгэлгээр гадаад улсад мэргэжил дээшлүүлэх зорилгоор 2 жилийн хугацаагаар суралцсан энэ тохиолдлыг тухайн байгууллагад “сул орон тоо үүссэн” гэж үзэхгүй буюу нэхэмжлэгч нь албан тушаал буураагүй, төрийн албанаас чөлөөлөгдөөгүй, өөр албан тушаалд шилжээгүй тул ажлын байрыг хадгалах үүрэг захиргаанд үүсчээ.

13.Учир нь Төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.3-т ““чадахуйн зарчим (мерит)” гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг ойлгоно” гэж тус тус зааснаар төрийн албыг мэргэшсэн, чадварлаг албан хаагчдаас бүрдүүлэх зорилгоор Засгийн газар хоорондын гэрээний дагуу тэтгэлэг олгож, төрийн жинхэнэ албан хаагчийг гадаад улсад суралцуулсан тул ийнхүү суралцсан төрийн албан хаагчийг төрийн албанд тогтвор, суурьшилтай ажиллах боломж нөхцөлийг хангаж байж, төрийн албыг чадварлаг, мэргэшсэн алба хаагчдаас бүрдүүлж, хөгжүүлэх зорилго биелнэ.

14.Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар болон Т.Батцэцэг нарын хооронд байгуулсан суралцах гэрээний Хоёрын 3-т “Оюутны

суралцах хугацаанд түр орлон гүйцэтгэгч ажиллуулах тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т заасны дагуу түр орлон гүйцэтгэгчийн ажлаас чөлөөлөгдөх хугацааг оюутны төгсөж ирэхээс өмнө байхаар тохируулж, оюутны буцаж ирэх үед нэн даруй өмнө нь ажиллаж байсан ажлын байранд буцаан авах эсхүл хөдөлмөрийн нөхцөлийг дордуулалгүй, ижил ажлын байраар хангана” гэж заасан, энэ үүднээс захиргааны байгууллага суралцагч албан хаагчийн ажлын байрыг хадгалах үүрэгтэй, нөгөө талаар гэрээний Хоёрын 4-т “Сургалтаа дуусган, буцаж ирсэн оюутныг нэн даруй ажлын байраар хангаж, суралцахаас өмнөх албан тушаалаас нь зэрэглэл, буруулалгүйгээр ажлын байраар хангаж 3 ба түүнээс дээш жилээр ажиллуулна” гэж зааснаар нэхэмжлэгчийн тухайд ч өмнө ажиллаж байсан байгууллагадаа тогтвортой ажиллах үүрэг хүлээсэн байгаа нь хуулийн дээрх зорилгод нийцсэн, захиргаа энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүрэгтэй, гэтэл төрийн захиргааны албан хаагч захиргааны зөвшөөрлөөр, Засгийн газар хоорондын гэрээний дагуу тэтгэлгээр 2 жил хүртэл хугацаагаар гадаад улсад суралцаж ирсэн байхад түүний эрхэлж байсан албан тушаалыг хадгалахгүй, үргэлжлүүлэн ажиллуулахгүй байх, орон тоо сулрахыг хүлээлгэх нь хуулийн дээрх зорилгод нийцэхгүй юм.

15.Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол эрх бүхий этгээд дараах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг төрийн жинхэнэ албан хаагчтай тохиролцсоны дагуу албан үүргийнх нь зэрэгцээ түр орлон гүйцэтгүүлж болно” гээд 42.1.4-т “зургаан сар хүртэл хугацаагаар мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан, 2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан” гэж заасан байх бөгөөд хуулийн энэхүү урьдчилсан нөхцөлийг нэхэмжлэгч Т.Батцэцэг хангасан буюу 2 жилээс илүүгүй хугацаагаар Засгийн газрын тэтгэлгээр өндөр хөгжилтэй оронд магистрын сургалтад хамрагдаж төгссөн тул хариуцагч захиргааны байгууллага нэхэмжлэгчийг урьд эрхэлж байсан ажил албан тушаалд томилох үүрэгтэй, энэ үүргээ биелүүлээгүй хууль бус эс үйлдэхүй гаргасан байна.

16.Энэ тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2-т заасан төрийн албанаас түр чөлөөлөгдөх зохицуулалт хэрэглэхгүй буюу дээр дурдсан “мэдлэг, чадвар бүхий албан хаагчдаас төрийн албыг бүрдүүлж, тэднийг тогтвортой ажиллуулах” хуулийн зорилгын хүрээнд захиргааны байгууллага нь өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан албан хаагчийн ажлын байрыг хадгалах, төгсөж ирсэн даруй ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах үүрэгтэй.

17.Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүхээс хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, “... төрийн албан хаагч 3 сараас дээш



хугацаагаар сургалтад хамрагдахаар болсон тохиолдолд түүнийг төрийн албанаас түр чөлөөлөхөөр, ийнхүү чөлөөлөгдсөн тохиолдолд төрийн албаны нөөцөд байгаад тооцохоор хуульчилсан, хариуцагчаас хууль бус эс үйлдэхүй гаргаагүй” гэж дүгнэж, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь буруу болжээ.

18.Дээр дурдсан үндэслэлээр “төрийн жинхэнэ албан хаагч 2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан тохиолдолд захиргааны байгууллага нь урьд эрхэлж байсан албан тушаалыг хадгалах, ажилд буцаан томилох үүрэгтэй” гэсэн агуулгаар хууль хэрэглээг тогтоож, шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах нь зүйтэй байна.

19.Хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчийн “төрийн албанаас түр чөлөөлөгдсөн иргэн төрийн албаны нөөцөд байхаар Улсын дээд шүүхийн 2019 оны 25 дугаар тогтоолтой хэргээр шийдвэрлэсэн, хууль хэрэглээтэй ижил агуулгатай байна” гэх тайлбарын тухайд,

20.Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 25 дугаар тогтоолоор Б.Туяагийн нэхэмжлэлтэй, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад холбогдох захиргааны хэргийг хянан шийдвэрлэхдээ, 2015 оны үйл баримтад холбогдуулан 2002 оны Төрийн албаны тухай хуулийг хэрэглэсэн нь энэ хэргийн тохиолдлоос өөр буюу энэ хэрэгт 2019 оноос хэрэгжиж эхэлсэн Төрийн албаны тухай хуулийг хэрэглэсэн, шинэ болон хуучин хуулийн үзэл баримтлал, холбогдох нарийвчилсан зохицуулалт ялгаатай, өөрөөр хэлбэл төрийн жинхэнэ албан хаагч “2 жил хүртэл хугацаагаар өндөр хөгжилтэй оронд магистр, докторын сургалтад хамрагдсан бол ажил, албан тушаалыг хадгалж, урьд эрхэлж байсан албан тушаалд томилох” агуулгатай зохицуулалт шинээр батлагдсан байх тул дээрх тайлбар үндэслэлгүй, шүүх адил тохиолдолд өөрөөр шийдвэрлэсэн гэж үзэхгүй.

21.Мөн “хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн, хоёр дахь удаагаа гаргасан гомдол байсан” гэх тайлбарыг хүлээн авах үндэслэлгүй, нэхэмжлэгчийн тухайд захиргааны байгууллагын хууль бус үйлдэхүйтэй маргасан буюу ажилд томилохгүй байгаа хууль бус эс үйлдэхүй үргэлжилж байсан, Монополын эсрэг газрын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 03/222 дугаар албан бичгийг хүлээн авч, 2025 оны 02 дугаар сарын 21-нд нэхэмжлэл гаргасан байх тул хөөн хэлэлцэх хугацаа хэтрээгүй.

22.Харин нэхэмжлэгчийн “ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговрыг гаргуулах” шаардлагын тухайд, Төрийн албаны тухай хуулийн 57.1-д “Төрийн албан хаагчид хууль болон албан

тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно” гэж заасан, нэхэмжлэгч нь бодитоор албаны чиг үүрэг хэрэгжүүлээгүй, ажиллаагүй тул холбогдох нэхэмжлэлийг хангах үндэслэлгүй, үндсэн цалин хөлстэй дагалдах эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх, дэвтэрт нөхөн бичилт хийхийг даалгах шаардлагыг мөн хэрэгсэхгүй болгов.

23.Гэрээний Хоёрын 2-т “Засгийн газрын 1994 оны 212 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-ын 2а-д заасны дагуу оюутны магистрын хөтөлбөрт суралцах хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар төлнө” гэж зааснаар ажилд буцаан томилох хүртэл хугацаанд хариуцагч нь нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэгтэй байна.

24.Хөдөлмөрийн тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1-д “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь үндэслэлгүйгээр цуцлагдсан ажилтныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр ажлын байранд нь эгүүлэн тогтоосон бол түүнд урьд нь эрхэлж байсан ажлыг нь гүйцэтгүүлж эхлүүлэх хүртэл хугацаанд өмнө нь авч байсан дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг ажил олгогч нөхөн олгоно” гэж заасан, энэ тохиолдолд маргааны үйл баримт нь хөдөлмөрийн харилцааг үндэслэлгүй цуцалсан маргаан биш тул уг зохицуулалтыг энэхүү маргаанд хэрэглэхгүй юм.

25.Нэхэмжлэгчийн “Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын даргын албан тушаалд томилохыг даалгах” нэхэмжлэлийн тухайд, хяналтын шатны шүүх хуралдаанд нэхэмжлэгчийн өмгөөлөгч болон хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгчийн тайлбартаа “хариуцагч байгууллагын бүтэц өөрчлөгдсөн” гэж тайлбарласан, хэрэгт авагдсан баримтаар маргаан бүхий албан тушаалд түр орлон гүйцэтгэгч ажиллуулж байгаа нь тогтоогдсон тул дараах байдлаар шийдвэрлэв.

26.Үүнд, нэгдүгээрт, хариуцагч Монополын эсрэг газар нь нэхэмжлэгч Т.Батцэцэгийг Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын даргын албан тушаалд томилох үүрэгтэй, хоёрдугаарт, хэрэв нөхцөл байдал өөрчлөгдөж, өмнө хэрэгжүүлж байсан ажлын байрны чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдээгүй бол Т.Батцэцэгийг өмнө эрхэлж байсан газрын даргын албан тушаалаас ангилал, зэрэглэл, цалингийн хэмжээ бууруулахгүйгээр адилтгах албан тушаалд томилох замаар шүүхийн шийдвэрийг биелүүлнэ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.2-т заасныг тус тус удирдлага болгон



ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн 128/ШШ2025/0615 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 221/МА2025/0698 дугаар магадлалын “Тогтоох” хэсгийн 1 дэх заалтыг “Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 42 дугаар зүйлийн 42.1.4-т заасныг баримтлан нэхэмжлэлийн “ажилгүй байсан хугацааны цалин хөлстэй тэнцэх олговрыг гаргуулах, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх, дэвтэрт нөхөн бичилт хийхийг даалгах” шаардлагыг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийн үлдэх хэсгийг хангаж, Т.Батцэцэгийг Монополын эсрэг газрын, Өрсөлдөөний зохицуулалт, зах зээлийн судалгааны газрын даргын албан тушаалд эгүүлэн томилохгүй байгаа Монополын эсрэг газрын даргын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, зохих журмын дагуу томилохыг даалгасугай” гэж өөрчилсүгэй.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Ц.ЦОГТ

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН
ШҮҮГЧИД**

**Д.МӨНХТУЯА
Г.БАНЗРАГЧ
М.БАТСУУРЬ
П.СОЁЛ-ЭРДЭНЭ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003

